



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 16 өдөр

Дугаар 1/62

Чингис хот

Гамшгаас хамгаалах команд штабын сургууль
зохион байгуулж, бэлтгэл ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Шадар сайд аймгийн Засаг даргатай 2018 онд хамтран ажиллах гэрээний 2.12, 3.10-т заасны дагуу "Гамшгаас хамгаалах команд штабын сургууль"-ийг 2018 оны 04 дүгээр сарын 25-27-ны өдрүүдэд зохион байгуулсугай.
2. "Гамшгаас хамгаалах команд штабын сургууль" зохион байгуулахтай холбогдуулан сургуулийн бэлтгэл ажлыг эрчимжүүлж ажиллахыг ажлын хэсэг, аймгийн онцгой комисс, албад, мэргэжлийн анги, сумдын Засаг дарга, байгууллага аж ахуйн нэгжийн дарга, эрхлэгч наарт үүрэг болгосугай.
3. Гамшгаас хамгаалах команд штабын сургуульд алба, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, машин, техник хэрэгслийн бэлтгэлийг ханггуулж бүрэн хамруулах, штабын байрыг зааврын дагуу байгуулж мэдээ мэдээллээр ханганд ажиллахыг гамшгаас хамгаалах орон нутгийн алба, мэргэжлийн ангийн дарга наарт даалгасугай.
4. Сургуультай холбогдуулан бусад төлөвлөгдсөн сургалт, семинар, олон нийтийг хамарсан үйл ажиллагааг хойшлуулах, хүндэтгэх шалтгаангүй сургуулийн нэгдсэн шуурхай цугларалт, сургалт, дадлага тасалсан албан хаагчдад холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, хурандаа Д.Батжаргалд үүрэг болгосугай.
5. Онцгой комисс, алба, мэргэжлийн анги, сумдын Засаг дарга, байгууллага аж ахуйн нэгжийн дарга, удирдах бүрэлдэхүүнийг сургуульд бүрэн хамруулах, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж удирдлагаар ханганд ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг даргын орлогч Г.Хэрлэнчулуунд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА